

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

Тарваган тахлыг эмчлэх, сэргийлэхэд хэрэглэж байсан уламжлалт анагаах ухааны эртний эмийн жорууд, түүхий эдийн судалгаа

Дэгвадорж Ц.¹, Байгальчимэг Б.², Жавхлан Б.³, Дармаа М¹, Болд Ш.^{1,2}

¹“Ач” Анагаах ухааны их сургууль

²Эм зүйн шинжлэх ухааны их сургууль,

³Graduate School of Medicine, Gunma University, Japan

Abstract

A Study on the Pharmacognosy Materials of Ancient Traditional Medicine Prescriptions Used to Treat Bubonic Plague

Dagvadorj Tserendorj¹, Baigalichimeg Batmunkh², Javkhlan Bold³, Darmaa Munkhdorj¹, Bold Sharav^{1,2}

¹“Ach” Medical University, Mongolia

²Mongolian University of Pharmaceutical Sciences, Mongolia,

³Graduate School of Medicine, Gunma University, Japan,

Correspondence: Bold Sharav, Mongolian University of Pharmaceutical Sciences, Mongolia.

Email: boldshrv@gmail.com

Background: Ancient Mongolian doctors and scholar-monks identified diseases that are not found in Indian Ayurveda or Tibetan medicine but were prevalent among Mongolians, in accordance with the theory of wind, bile, and phlegm, leading to a revision of disease classification. A notable example is the entirely new systematization of the classification, nomenclature, diagnosis, and treatment of infectious diseases. Consequently, it is essential to examine the texts of Mongolian doctors and maarambas who have made significant contributions in this field and have worked to revitalize and advance knowledge in this area. **Objective:** The research objective is to identify medicinal raw materials used in prescriptions for the bubonic plague that occurred in Mongolia, which were not included in the classification of infectious diseases in the “Ashtanga hridaya samhita,” one of the three major Ayurvedic works, and the “Four Medical Tantras”, the principal text for training Tibetan and Mongolian doctors. **Methods:** This study utilized source analysis of ancient texts and the checklist method as research methods. **Conclusion:** The renowned Mongolian medical scholar Ishbaljir authored his book “Rashaani tsagan sevder” in 1753, in which he claimed to be the first Mongolian physician to write about marmot poisoning or bubonic plague. Historically, Mongolian ancestors and nomadic communities have long employed various methods to prevent and treat infectious diseases. Over time, these practices were adapted and enriched to suit regional characteristics, extreme climates, unique living conditions, and the physiological traits of the population. Some approaches were newly discovered, while others evolved through generations of experience. Through this process, these methods

contributed to the development of a unique and comprehensive body of medical knowledge, shaped by the cognitive and scientific advancements of ancient doctors and maarambas.

Keywords: ancient doctors, bubonic plague, infectious disease, Mongolian doctors, Tibetan medicine.

Рр. 123-130, Picture 1, References 27

Судалгааны ажлын үндэслэл

Бурхны шашны хожуу дэлгэрэлтийн үе буюу XVI зууны сүүл үеэс эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухаанаас эхтэй анагаах ухааны эртний номуудыг монгол хэлээр орчуулж эхэлсэн. Эдгээр судар номын дотроос Монголд ихэд дэлгэрсэн нь Хутагт Вагбатын НТ VII-VIII зуунд бичсэн “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй” гэдэг ном юм. Үүний зэрэгцээ Төвөдийн анагаах ухааны эмч бэлтгэдэг үндсэн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс” Монголд дэлгэрсэн. Энэ бүтээлд суурилсан анхны эмч бэлтгэдэг сургууль 1681 онд Ар Монголд байгуулагдсанаас хойш энэхүү номыг орчуулах, тайлбар бичих, зарим агуулгыг нь шинэчлэх талаар монгол эмч, эрдэмтэн лам нар чухал үүрэг гүйцэтгэжээ. Ялангуяа эмийн жорд ордог амьтан, ургамал, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийг Монголоос гардаг эмт бодисоос бэлтгэхэд ихээхэн анхаарч эхэлсэн.

Түүнчлэн Энэтхэг, Төвөдөд гардаггүй боловч Монголчуудад тохиолддог өвчнийг хий, шар, бадганы онолд нийцүүлэн шинээр тогтоон улмаар өвчний ангиллыг шинэчилсэн. Үүний нэг тод жишээ бол халдварт өвчний ангилал, нэршил, оношилгоо, эмчилгээг цоо шинээр системчилсэн явдал юм. Тиймээс энэ чиглэлд ихээхэн хувь нэмэр оруулсан, энэ талын мэдлэгийг шинэчлэн боловсруулах ажлыг хийсэн монгол эмч, маарамбуудын бүтээлийг судлах асуудал чухал байна [1,2]. Ингэж уламжлалаа эргэн харж, өвөг дээдсийнхээ үлдээсэн мэдлэгийн их санг судлан, үнэт зүйлийг нь тодруулснаар цаашид уг уламжлалт анагаах ухааныг зөв, оновчтой хөгжүүлэх үндсийг баттай болгох, орчин цагийн анагаах ухаантай оновчтой хослуулан хөгжүүлэх учиртай юм [3].

Иймд бид энэ чиглэлийн судалгааны жишээ болгож халдварт өвчний талаарх түүхэнд холбогдох зарим эх сурвалж, баримтууд, анагаах ухааны ном судрыг судлан судалгааны эргэлтэд оруулах, сургалт, судалгаанд ашиглах, олны хүртээл болгохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Судалгааны ажлын зорилго

Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны их гурвалын нэг “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй”, Төвөд, Монголын анагаах ухааны эмч бэлтгэдэг үндсэн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс” номын халдварт өвчний ангилалд ороогүй, Монголд тохиолддог тарваган тахалд хэрэглэж байсан жорд ордог эмийн түүхий эдийг тогтоох зорилго тавилаа.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга

Нэг. Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнд дараах анагаах ухааны эртний судар номыг ашиглав. Үүнд:

1. Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр хэмээх оршвой”. Монгол бичгийн гар бичмэл анагаах ухааны эртний ном (1753 он). Академич Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна.
2. Тойн Лувсанчойнпил. Нандин эрдэнийн шимийн хураангуй. Монгол хэлээр орчуулсан анагаах ухааны гар бичмэл эртний ном (1845 он). Академич Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна.
3. Гэлэн Чойжамц. Маш гайхамшигт баярын хуримын сан хэмээх оршвой.

Боть 51. Төвөд хэлнээс орчуулж, тайлбар хийсэн О.Дэмчигмаа, Ш.Болд. Ариутган шүүсэн Ш.Чоймаа. УБ, 2026, 276х

Хоёр. Судалгааны ажлын арга

Эх бичиг судлалын арга

Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилго, зорилтуудад нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацааг хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлж, сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, хөрвүүлгийн судалгааг хийж улмаар бүтээлийн гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзэв.

Магадлан жагсаах арга

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь уламжлалт анагаах ухаан дахь халдварт өвчинтэй холбоотой мэдээллийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгийг тогтоох арга юм. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад, өгөгдөл цуглуулахад хялбар, цахим санд оруулахад хялбар байдгаараа халдварт өвчний талаарх мэдээллийн сан бүрдүүлэх үндэс болсон.

Судалгааны ажлын үр дүн

Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны их гурвалын нэг “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй” ном нь 120 бүлэг, 7120 шад шүлгээс бүрдсэн ном юм [4]. Харин Төвөдийн анагаах ухааны эмч бэлтгэдэг үндсэн ном “Анагаах ухааны дөрвөн үндэс” нь 156 бүлэгтэй, 5900 шад шүлгээс бүрдсэн байдаг [5]. Арван долоодугаар зууны Төвөдийн анагаах ухааны нэрт зүтгэлтэн Дэсрид Санжаажамц (Sde srid Sangs rgyas rgya mtsho, 1653–1705) “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-ийн тайлбар “Манаг Лхантав” номдоо янз бүрийн хүнд өвчний үе шат, халдварт өвчний үүсгэгчийг тодорхой болгохын тулд

нян гэсэн ойлголтыг тодруулж өгсөн байдаг [6].

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-т: “Нян хижиг өвчний бүлэгт шалтгаан, нөхцөл, орох үүд, шинж тэмдэг дээр үндэслэн ерөнхий ба тусгай гэж хуваагаад 4 бүлгээр өгүүлсэн. Үүнийг Дэсрид Санжаажамц “Манаг Лхантав” номд 18 бүлэг болгон ангилж нийт 22 халдварт өвчин болгосон [7].

Энэ ангиллаас үзэхэд “Анагаах ухааны дөрвөн үндэс” номын онол, арга зүйн үндэс нь эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны их гурвал зохиол тухайлбал “Найман гишүүнтийн зүрхний хураангуй” бүтээлээс гаралтай учраас халдварт өвчний ангилал нь ойролцоо байна. Түүнчлэн энэхүү 2 номын халдварт өвчний ангилалд тарваган тахлын тухай бичээгүй байна. Тиймээс монгол эрдэмтэн лам нар өөрсдийн бичсэн анагаах ухааны судар номд тарваганы өвчнийг шинээр нэмж оруулжээ. Учир нь тарвага нь Монгол оронд элбэг байдаг, хоол хүнсэнд өргөн хэрэглэдэг. Тарваганаас хүнд халддаг, нянгаар үүсгэгддэг өвчин гардгийг олж тогтоон шинээр тарваганы халдварт өвчний ангилал зохиожээ.

Бид судалгааны үр дүнд тарваганы өвчин, түүний эмчилгээний талаар монгол эрдэмтэн лам Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) анхлан өөрийн бүтээлдээ албан ёсоор бичсэн гэж тогтоов. Судалгааны явцад Сүмбэ хамба Ишбалжираас гадна Лувсанчойнпил тойн (XIX зуун), Гэлэн Чойжамц (XIX зууны сүүлч XX зууны эхэн) нар өөрсдийн бичсэн анагаах ухааны номдоо тарваганы тахлын эмчилгээ, урьдчилан сэргийлэх аргын тухай бичиж үлдээжээ [8].

1. Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788)

Ишбалжир 1704 онд Дээд Монголд төрсөн. Залуу наснаасаа орон нутагтаа болон бусад оронд очиж буддын шашны мэдлэгээс гадна анагаах ухаанд суралцаж, сайтар эзэмшсэн. Ялангуяа Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны сонгодог зохиолд нэвтэрсэн, дадлагын явцдаа Монгол оронд зонхилон

тохиолддог өвчнийг эмчлэх талаар ихээхэн туршлагыг хуримтлуулсан байна. Түүний бичсэн анагаах ухааны том, жижиг 7 зохиол нь Монголын уламжлалт анагаах ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан. Ялангуяа Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны онол, туршлагыг Монгол орны уур амьсгал, байгалийн баялаг хийгээд Монгол үндэстний амьдрах орчин, эрхлэх аж ахуй, өвчлөлтэй уялдуулж бодитойгоор судалсан бүтээл юм. Иймээс эдгээр номууд Монгол хөрсөнд бууж чадсан, онолын хувьд цоо шинэ санаа, эмчилгээний аргуудыг нээж өгснөөрөө гавьяатай юм [9].

Сүмбэ хамба Ишбалжир “Рашааны цагаан шүүдэр” номоо 1753 онд 49 насандаа бичсэн байна. Одоогоор бидний олж тогтоосноор энэ номоос өмнө нь тарваган тахлын талаар бичсэн бүтээл олдоогүй байна. Тиймээс тарваганы өвчний тухай анх бичсэн эрдэмтэн бол Сүмбэ хамба Ишбалжир юм гэж тогтоов. Үүнийгээ батлахын тулд уг сударт байгаа баримтыг дараах байдлаар тодруулав. Сүмбэ хамба Ишбалжир “Рашааны цагаан шүүдэр” судартаа:

“Ичээндээ байгаа өвчтэй тарваганы махыг идвэл тарваганы хижгээр өвчилнө. Эмчлэх арга нь цасанд өвчүүгээ наалдуулбал хор нь татагдаж цас шарлана. Цасны усыг үүрээр уулгах эсвэл үүрээр нуурын усанд дахин дахин орж муухай үнэр нь арилбал засарна. Найруулсан хорыг засах үед гарсан эрдэнийн хар үрлийг өгч, хар мэлхий, хар хулганын цусыг уулгах ба хор тайлах эмүүд, жич: хорын туулга нугууд тусална. Эсвэл эрдэнийн хар үрлийг найруулж өгвөл хорыг дарж, тарваганы хороос сэргийлж чадна” гэжээ. Сүмбэ хамба Ишбалжир энэхүү номдоо тарваган тахлыг тарваганы хор эсвэл хижиг (халдвар) гэж нэрлэсэн байна. Эрдэнийн хар үрэл эмийн жор нь 77 бүрэлдэхүүн буюу түүхий эдээс бүрддэг. Найруулахад төвөгтэй зарим эмийн түүхий эдийг өнөө цагт таних, олох боломжгүй байна.

Харин Сүмбэ хамба Ишбалжир өөр нэгэн ном “Рашааны дусал”-д: “Тарваганы хор

өвчинд есөн харын найрлагыг уулгах буюу түрхвэл сэргийлж чадна. Өглөө бүр өлөн дээр нь саримс, архинд найруулан уулгана. Өглөө архи ууж, нуур буюу голын хүйтэн усанд ороод дагжин чичиртэл суулгаад дараа нь есөн харын найрлагыг уулган хэдэнтээ хөлөргөнө. Хөлс гарах үед хор нь их бол илжирсэн мах адил муухай үнэр гарсны эцэст дахин цас буюу мөсөнд өвчүү хийгээд богино хавиргыг нь наахад тэр цас мөс нь шарлаваас тусалж байгаагийн шинж юм” гэжээ [10]. Есөн харын найрлагад:

1. Алтан өнгөт арүр
2. Бона
3. Үхрийн цөсний чулуу
4. Гүгэл
5. Заар
6. Шудаг
7. Өмхий давирхай
8. Хүхэр
9. Хар бэх

Есөн харыг зүүх буюу уухад тарваган тахлаас гадна аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эсвэл уг өвчнийг хүндрүүлэхгүй байх ихээхэн ач холбогдолтой [11].

2. Тойн Лувсанчойнпил


Лувсанчойнпил нь XIX зууны үед амьдарч байсан тойн сахилтай Монголын шашны мэдлэг ухааны нэрт төлөөлөгч хүн. Анагаах ухааны чиглэлээр туурвисан томоохон ном нь “Gces btus snying nor” (Нандин эрдэнийн шимийн хураангуй) гэдэг 234 хуудастай, 1845 онд бичсэн ном [12]. Энэхүү номд:

Тарваганы өвчин нь өвчтэй тарваганы мах идсэнээр богино хавирга өвдөх шинж тэмдгээр илэрдэг халдварт өвчин юм. Тэрээр номдоо тарваганы өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын талаар: “Өглөө бүр өлөн үедээ саримстай архи найруулан уулгавал халдахгүй. Бүх гөрөөс буюу бүдүүн сарлагийн хатаасан цусыг нэг тунг уулгах ба саримсыг тосонд буцалгаж өглөө ам, хамарт нь түрхвэл тарваганы хор тусахгүй” гэх мэтээр бичжээ. Уг номд ургамлын гаралтай саримснаас гадна эрүүл

сарлагийн цус гэсэн амьтны гаралтай эмийн түүхий эдийг ашиглах талаар зөвлөжээ. Мөн арвайн гурилыг тостой шатаасан хэншүүг үнэртүүлэх ба аргалын утаагаар утаж, хатсан лууван, манжинг буцалгаж уулгавал тусална [13] гэсэн байна.

3. Гэлэн Чойжамц (XIX зууны сүүлч XX зууны эхэн) Гэлэн Чойжамц XIX зууны сүүлч XX зууны эхэнд амьдарч байсан

бөгөөд уг нь бурхан бүтээдэг мэргэжилтэй боловч эмийн номд гаргуун сайн байжээ. Тэрээр хэдийгээр монгол лам боловч "Маш гайхамшигт баярын хуримын сан" хэмээх 11х26 см, 206 хуудастай номыг 1921 оноос 1922 оны намрын сүүл сар хүртэл төвөд хэлээр бичсэн [14]. Түүний энэхүү судрын 86 дугаар хуудсанд тарваганы халдварт өвчний талаар тодорхой бичсэн [15] (Зураг 1).



Зураг 1. “Маш гайхамшигт баярын хуримын сан хэмээх оршвой” судрын тарваганы өвчнийг эмчлэх тухай бичсэн нүүр

Picture 1. A page about treating bubonic plague written in the “Ngo mtshar dga’ ston gter mdzod” scriptures

Rtsibs thung lha mo (Goddess’ short rib), монголоор охин тэнгэрийн богино хавирга гэдэг маш халдвартай өвчин юм. Тарваганы махыг идэх хийгээд дууг сонссон тэргүүтэнд халдана. Шинж тэмдэг нь: Толгой манарч, амьсгал ширүүн болж, дэлүүн дор халуун их болж, бороор бөөлжиж, тэнхээ тамир муудан, уушги, зүрх дэлсэнэ. Хавирганы дээр халуун оргиж, догшин халуун хавдар гарна. Тарваганы өвчнийг эмчлэхэд Co’u sha u bo wan (Жоу шау бован) эмийг өгнө. Найрлагад нь:

1. Цалгод 010, (Чулуун шунх - Cinnabar)
2. Гиван 100, (Үхрийн цөсний чулуу – Bos taurus domesticus Smelin)
3. Жисүн 050, (Шивээ өвс – Arctium lappa)
4. Донрой 020, (Эр алтан хүхэр - Realger)
5. Бавруу 050, (Цээнэ - Paeonia anomala L)

Эдгээрийг сайтар нунтаглан буурцаг буюу товчийн чинээ үрэл болгож, балаар зуурч

сувс архиар даруулж ууваас хий, шар хийгээд ханиах, амьсгаа амаргүй болох, дэмийрч халуурах, тарваганы хор, нохойн хор, суулгаж бөөлжих, улаан эсэргэнэ, цэцэг өвчин, хорхой, цул савын халуунд тус их мөн болой гэжээ [16].

Co’u sha u bo wan (Жоу шау бован) жорын 5 эм тус бүрийн хэрэглээг уламжлалт эмийн түүхий эдийн гол ном Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, Монгол судлалын нэвтэрхий толиос дараах байдлаар тодруулав.

1. Цалгод (Чулуун шунх - Cinnabar)

Амтлаг амттай, сэрүүн чанартай, хортой эрдэс юм. Хиймлээр гарган авдаг [17]. Гол бүрэлдэхүүн 86.2% нь мөнгөн ус, 13.8% нь хүхэр болно [18]. Саа өвчин, хүүхдийн тахал, хавдар, хор тайлах, мэдрэлийн судасны гэмтэл, яр шархыг эмчлэх үйлдэлтэй.

2. Гиван (Үхрийн цөсний чулуу – *Bos taurus domesticus* Cmelin)

Гиван нь гашуун амттай, сэрүүн хүнд чанартай. Монголд голдуу үхрийн цөсний чулуу, хиймэл гиванг эмд хэрэглэдэг. Гиван нь хижиг, хор, элэгний өвчин, савын халууныг арилгана [19].

3. Жисүн (Шивээ өвс – *Arctium lappa*)

Жисүн гашуун амттай, хүйтэн чанартай. Чулуун бэтгийг эвдэж, шээлгэх, судасны өвчинг засах үйлдэлтэй [20].

4. Донрой, (Эр алтан хүхэр - *Realger*)

Эр алтан хүхэр нь гашуун амттай, бүлээн, хүнд чанартай, хортой эрдэс. Булчирхай, ялзарсныг тасална. Ялангуяа ад хийгээд хижгийг сахина. Сахууг эмчлэх эмийн дээд мөн хэмээжээ [21]. Ерөнхийдөө нян өвчин, чийх буюу янз бүхийн хавдар, хоолой хавдахад нэн тустай байдаг.

5. Бавруу, (Цээнэ - *Paeonia anomala* L)

Цээнийн үндэс нь амтлаг, гашуун амттай, бүлээн, хөнгөн чадалтай. Шээс хөөх, шимжүүлэх, цус алдах, толгой өвдөхийг намдааж, хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааг сайжруулна [22].

Гэлэн Чойжамцын "Маш гайхамшигт баярын хуримын сан" номдоо дурдаад байгаа *Co'u sha u bo wan* (Жоу шау бован) жор нь өнөөгийн мэдлэгийн хэрээр олдоод байгаа эм судлал, эм найрлагын судар номуудад тэмдэглэгдээгүй байна. Тиймээс энэ жор нь Чойжамцын өөрийн шинээр нээсэн эм байж болох юм гэсэн таамаг дэвшүүлээ. Цаашид энэ жорыг нарийвчлан судлах шаардлагатай юм.

Хэлцэмж

"Анагаах ухааны дөрвөн үндэс"-т "Нян өвчин цусны оронд орших зэс мэт нарийн болоод үл үзэгдэх хорт хорхойгоос үүснэ." Хий, шар, бадганыг хураасан үүсгэгч нь орон, цаг, идээ ундаа, явдал мөрийн нөхцөлөөр хорхой хямарч биеийн тамирыг идэн нян болно" гэж өгүүлжээ [23]. "Анагаах ухааны дөрвөн үндэс" судрын "Увдисын үндэс"-ийн

тайлбар, Дэсрид Санжаажамцын "Манаг Лхантав" номд: "Нян өвчин нь нэг зүйлийн хумх хорхойгоос үүсдэг гэж үзээд хумхын хорхой нь гүрвэл мэт толгойтой, гэгээ завсрын орноос шар үсэнд үсний нүх ба хамрын үүдээр орно. Биеийн дотор буй агч хорхой нь улаан өнгөтэй, хөлгүй бөөрөнхий бөгөөд жижиг нарийн, хүний нүдэнд үзэгдэхгүй, нэгэн агшинд судлын дотуур бүх биед гүйж чаддаг цусны хорхойтой хамт оршиж, хамаг нян өвчний шалтгаан болдог" гэжээ [24]. Үүнийг тодруулбал, гаднаас хорхой орж, биед оршиж байгаа дотоод хорхойн хамтаар нян өвчин үүснэ гэсэн утгатай юм. Тиймээс хижиг өвчин гэдэг нь үндсэндээ ямар нэгэн нян хорхойгоор үүсгэгддэг болох нь тодорхой байна. Тарваганы хор, хижиг нь тарваганы нян биед халдварлаж гурван гэмийг хямралдуулснаас үүсэж байна.

Сүмбэ хамба Ишбалжирын 1753 онд бичсэн "Рашааны цагаан шүүдэр"-ээс өмнө нь тарваганы хор буюу өвчний талаар бичсэн бүтээл одоогоор олдоогүй байна. Түүний "Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр хэмээх оршвой" сударт, ичээнд байгаа өвчтэй тарваганы махыг идвэл тарваганы хижгээр өвчилнө. Засах арга нь цасанд өвчүүгээ наалдуулбал хор нь татагдаж цас нь шарлана. Цасны усыг үүрээр уулгах ба үүрээр нуурын усанд дахин дахин орж муухай үнэр нь арилбал засарна. Найруулсан хорыг засах үед гарсан эрдэнийн хар үрлийг өгөх, хар мэлхий, хар хулганы цусыг уулгах ба хор тайлах эмүүд, жич хорын туулга нугууд тусална [25] гэжээ. Эсвэл эрдэнийн хар үрлийг найруулж өгвөл хорыг дарах хийгээд хороос сэргийлж чадна. Энэхүү эрдэнийн хар үрлийн тухай нарийвчлан хийсэн судалгаа одоогоор алга байна. Түүний дараагийн бүтээл болох "Анагаах ухааны увдисыг машид цөөлөн хураасан рашааны дусал хэмээх оршвой" сударт: Тарваганы хор нь "Богино хавиргат охин тэнгэр" хэмээх богино хавирга өвдөх халдварт өвчинд номлогдох болсон өвчнийг хэлнэ. Үүнд, хожим гаргах есөн харын найрлагыг уулгах буюу түрхвэл сэргийлж

чадна. Өглөө бүр өлөн дээр нь саримс, архинд найруулан уулгаснаар ч эс тусна хэмээдэг.

Судалгааны явцад бидний ажигласан нэгэн чухал зүйл бол тарваганы хижгээр өвдөгсдийг эмчлэхийн зэрэгцээ хэрхэн сэргийлэх аргуудыг олонтоо дурдсан байна. Тарваганы хижгээс сэргийлэх талаар Ишбалжираас гадна Лувсанчойнпил тойн номдоо: “Өглөө бүр өлөн үедээ саримстай архи найруулан уулгавал халдварлахгүй. Бух гөрөөс буюу бүдүүн сарлагийн хатаасан цусыг нэг тунг уулгах ба саримсыг тосонд буцалгаж өглөө ам, хамарт нь түрхвэл хор тэрээр тусахгүй гэх зэргээр бичсэн байна [26]. Есөн харын найрлагыг ууж хэрэглэхээс гадна зүүж сэргийлдэг төдийгүй ямар ч халдварт өвчнөөс сэргийлэх боломжтой юм. Манай улс “COVID-19” буюу “Шинэ коронавирус”-ийн цар тахлын үед 9 харын найрлагыг зүүх, утах, биедээ түрхэх, уухыг зөвлөж байсан. Энэ эм нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, цаашид өвчнийг хүндрүүлэхгүй байхад чухал ач холбогдолтой юм [27].

Дүгнэлт

Монголын бурхан шашны болон анагаах ухааны нэртэй зүтгэлтэн Сүмбэ хамба Ишбалжирын 1753 онд бичсэн “Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр” номдоо Монголын эмч, маарамба нараас хамгийн анх тарваганы хор буюу тарваганы хижиг өвчний талаар бичсэн эрдэмтэн лам гэдгийг тогтоов. Монголчуудын өвөг дээдэс, нүүдэлчид түүхэн урт хугацааны турш халдварт өвчин, эмгэгтэй тэмцэх, түүнийг эмчлэх аргыг хэрэглэх явцдаа газар нутгийн онцлог, байгаль, цаг уурын эрс тэс байдал, аж амьдралын өвөрмөц нөхцөл, бие махбодын онцлогтойгоо тохирсон шинэ, шинэ аргуудаар баяжуулахын зэрэгцээ зарим аргыг шинээр нээн гаргажээ. Хөгжлийн явцад энэхүү аргууд нь эртний эмч маарамба нарын сэтгэлгээ, танин мэдэхүйн хөгжил, дэвшлийн нөлөөгөөр

өвөрмөц онцлог бүхий мэдлэг ухааны цогц ойлголтыг бий болгосон байна.

Ном зүй

1. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Улаанбаатар, Адмон ХҮ, 2006, х.248
2. Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч академич Ш.Болд, академич Д.Цэрэнсодном) УБ, 2014, х.24
3. Дагвадорж Очирбат. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн намтар, анагаах ухааны зарим зохиолын агуулга, онцлогийг тогтоох нь. Анагаах ухааны докторын зэрэг (Ph.D) горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2026, х.14-15
4. Vagbhata's Astanga Hrdayam. Translated by Prof. K.R. Srikantha Murthy. Vol 1-3. Krishnadas Academy, Varanasi, 1994
5. Рашааны зүрхэн найман гишүүнт нууц удисын үндэс. Орчуулсан Минжүүр гүүш. 1727 он, монгол бичгийн барын ном.
6. Tawni Tidwel, Khenrab Gyamtso. Tibetan Medical Paradigms for the SARS-CoV-2 Pandemic. Asian Medicine 16 (2021) 89–127.
7. Khenrab Gyamtso. A Brief Introduction to Virulent Infectious Disease (Nyen-rim) in the Tibetan Medical Canon: Etiology, Diagnosis and Treatment. Webinar Dialogue Series: Encountering COVID-19: Perspectives from Tibetan Medicine. <https://www.kundewellness.org/uploads>.
8. Цэрэндоржийн Дагвадорж. Халдварт өвчинтэй тэмцсэн түүхийг эх сурвалжаар тодруулах нь (18-20 дугаар зуун). Анагаах ухааны докторын зэрэг (Ph.D) горилсон нэг сэдэвт бүтээл. “Ач” АУИС, УБ, 2026, х.68-70
9. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл.” УБ, 2020, х.168

10. Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах ухааны увдисыг машид цөөлөн хураасан рашааны дусал хэмээх оршвой”. Гар бичмэл монгол орчуулга
11. Жамбалчойжиданзанпэрэнлэй (1789-1838 он) “Увдисын далай”.
12. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл.” УБ, 2020, х.277-278
13. Лувсанчойнпил тойн. Нандин эрдэнийн шимийн хураангуй (1845 он). Гар бичмэл монгол орчуулга
14. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл.” УБ, 2020, х.325
15. Чойжамц. Маш гайхамшигт баярын хуримын сан хэмээх оршвой. Боть 51. Төвөд хэлнээс орчуулж, тайлбар хийсэн О.Дэмчигмаа, Ш.Болд. Ариутган шүүсэн Ш.Чоймаа. УБ, 2026
16. Чойжамц. Маш гайхамшигт баярын хуримын сан хэмээх оршвой. Боть 51. Төвөд хэлнээс орчуулж, тайлбар хийсэн О.Дэмчигмаа, Ш.Болд. Ариутган шүүсэн Ш.Чоймаа. УБ, 2026, х.253
17. Жамбалдорж. “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (1817-1823 он). Гар бичмэл монгол бичгийн ном (Орчуулагч тодорхойгүй). х.32
18. Монгол судлалын нэвтэрхий толь, Анагаах ухаан. ӨМ-ын АХХ, 2002, х.814
19. Жамбалдорж. “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (1817-1823 он). Гар бичмэл монгол бичгийн ном (Орчуулагч тодорхойгүй). х.42
20. Монгол судлалын нэвтэрхий толь, Анагаах ухаан. ӨМ-ын АХХ, 2002, х.949
21. Жамбалдорж. “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (1817-1823 он). Гар бичмэл монгол бичгийн ном (Орчуулагч тодорхойгүй). х.28
22. Монголын уламжлалт анагаах ухааны эм нсудлал. Төслийн удирдагч Ш.Болд, Д.Цэрэнсодном. УБ, 2022, х.268
23. Анагаах ухааны дөрвөн үндэс. Орчуулсан Минжүүр гүүш. Модон барын монгол судар. 1727 он
24. Дэсрид Санжаажамц. “Манаг Лхантав”. Төвөд, тод үсгийн гар бичмэл монгол судар
25. Сүмбэ хамба Ишбалжир. Рашааны цагаан шүүдэр. Орчуулсан анагаах ухааны доктор Ш.Болд, лам Б.Дагвадорж. УБ, 1997
26. Лувсанчойнпил тойн. Нандин эрдэнийн шимийн хураангуй (1845 он). Гар бичмэл монгол орчуулга
27. Коронавирус: Академич Ш.Болд, П.Нямдаваа нарын зөвлөмж. <https://news.mn/r/2265174/>

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Акадмич Ч.Чимэдрагчаа*